



СЭНТРАЛ ЭКСПРЕСС СИ ВИ ЭС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 11










Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалт татах,
сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн дэлгүүрийн тэлэлт болон хоол боловсруулах үйлдвэр, түгээлтийн төвд шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, 91 дүгээр зүйлийн 91.2 дох заалт, Компанийн Дүрмийн 9.4.18 дах заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийг 2023 оны 12-р сарын 31-ний өдрөөс өмнө энгийн хувьцаанд хөрвүүлэх нөхцөлтэй 30,000,000,160 (гучин тэрбум нэг зуун жар) хүртэлх төгрөгийн хөрөнгө оруулалтын урьдчилгааг Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Премиум Групп ХХК-иас 2023 оны 12-р сарын 01-ний өдрөөс өмнө үе шаттайгаар авахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн нь Премиум Групп ХХК-иас авсан хөрөнгө оруулалтыг Компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжгүй болсон тохиолдолд дээр дурдсан санхүүжилтэд санхүүжилт авсан өдрөөс эхлэн зах зээлийн түвшинд хүүгийн зардал тооцож Премиум Групп ХХК-д эргүүлэн төлөхийг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

| | | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|--------------------|--|------------|------------|
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: | А.ГАНХУЯГ |  | | |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: | А.ГАНБОЛД |  | | |
| | О.БАТМӨНХ |  | | |
| | Г.БАТ-ЭРДЭНЭ |  | | |
| | Г.ЧИНЗОРИГ |  | | |
| | Б.БАТ-ЭРДЭНЭ |  | | |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: | Н.ЭНХБОЛД |  | | |
| | В.ГАНЗОРИГ |  | | |
| | ГАРИ СТИВЕН БИОНДО |  | | |
| Тогтоолын батлагдсан хувь: | | 100% | | |